



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайланд залруулга хийх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,068,327,203.00 (нэг тэрбум жаран найман сая гурван зуун хорин долоон мянга хоёр зуун гурван) төгрөгийн балансын үнэ, 71,221,813.51 (далан нэгэн сая хоёр зуун хорин нэгэн мянга найман зуун арван гурван төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ажилчдын орон сууц нэрээр бүртгэлтэй, үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, тайланд холбогдох стандартын дагуу тусгаж, залруулга хийхийг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийн залруулга хийх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

